



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/392

Арвайхээр

┌ Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл ┐
олгох тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 30 дугаар зүйлийн 30.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2020 оны 172 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Хархорин суман дахь шашны ахлах сургуулийн бүтэц, хэв шинж өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус сургуулийг Хархорин сумын математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн, нийгмийн ухааны төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Номын хүрдэн” сургууль болгон өөрчилж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Хархорин сумын математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн, нийгмийн ухааны төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Номын хүрдэн” сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ОРЛОГЧ  О.БАТЖАРГАЛ

011100755